



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/349

Мандалговь

“Дуурьсал” хамтлагт дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин, Зууны манлай, Алдарт уртын дуучин Н.Норовбанзадын нэрэмжит Төв Халхын дуулалт жүжгийн театраас 2015 онд уран бүтээлийн гараагаа эхэлж, “Этник поп” чиглэлээр уран бүтээлээ туурвиж буй “Дуурьсал” хамтлаг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо “Дуурьсал-2019” уран бүтээлийн тоглолтоо хийхтэй холбогдуулан санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Дэмжлэгт 1000000 (Нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190992